



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Сар шинийн баяр угтсан зарим арга
хэмжээг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/51 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Автомашины улсын дугаарын хязгаарлалт тогтоосон амралтын өдрүүд буюу 2017 оны 02 дугаар сарын 11,18-ны Бямба гараг, 02 дугаар сарын 12,19-ний өдрийн Ням гарагуудад Дэнжийн мянгын “Хүчит шонхор” худалдааны төвийн авто замын хөдөлгөөнд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан “Дэнжийн мянга” чиглэлийн замын хөдөлгөөний зураглалыг нэгдүгээр, алслагдсан гэр хорооллоос “Нарантуул” олон улсын худалдааны төв хүртэл үйлчлэх тээврийн хэрэгслийн тоо, аж ахуйн нэгж байгууллагын нэр, чиглэлийн зураглалыг хоёрдугаар, Нарантуул ОУХТ, Хүчит шонхор зах дээр ажиллах автотээврийн хяналтын улсын байцаагч, жолооч нарын ажиллах хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баяр угтсан өдрүүдэд үйлчилгээний хэвийн, тогтвортой, шуурхай байдлыг хангаж ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, иргэд үйлчлүүлэгчдийн санал гомдолгүй, зам тээврийн осол зөрчилгүй, соёлтой үйлчлэх талаар нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтарсан бүх талын арга хэмжээг авч ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /С.Нямдорж/-т тус тус үүрэг болгосугай.


3. Хяналт шалгалтаар ажилласан автомашины шатахууны зардлыг гүйцэтгэлээр тооцож, амралтын өдрүүдэд ажилласан ажилтнуудыг биеэр нөхөн амраахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т үүрэг болгосугай.

4. Нийслэлийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх хугацаанд Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн ажиллагааг хангаж нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагуудын тухайн

өдрүүдийн ажлын гүйцэтгэлийг тооцохдоо анхаарч ажиллахыг Улаанбаатар смарт карт компани / Юүн Жун И /-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Доржпалам/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНБААТАР

